

АГУУЛГА

1. ОРШИЛ	2
1.1. Төслийн товч тодорхойлолт	2
1.2. 2023 оны уулын ажлын хэмжээ, ажиллах горим	3
1.3. Ил уурхайн ажиллах горим	3
1.4. Ашиглалтын систем	4
1.5. Ил уурхайн нээлт болон ашиглалтын дараалал	5
1.6. ДАЛД УУРХАЙН ОЛБОРЛОЛТ	6
1.6.1. Далд уурхайн ажиллах горим	6
1.6.2. Ашиглалтын систем	7
1.6.3. Үндсэн болон бэлтгэл малталт нэвтрэлт	8
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	11
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	12
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	12
3.2. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	12
3.3. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	12
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	14
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт	14
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	18
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	23
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	27

1. ОРШИЛ


Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Тавт” нэртэй МУ-021055 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь Дэлгэрхааны хайлуур жоншны өмнөд хэсгийн ордыг ил, далд аргаар ашиглах 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг тус ордын талбайн хайгуулын ажлын нөөцийн тодотгол тооцооны тайлан, 2022 оны 1-р сард батлуулсан ТЭЗҮ-н тодотгол, тушаал дүгнэлт зэрэг материалыг үндэслэн боловсруулав.

1.1. Төслийн товч тодорхойлолт

Ордын тодорхойлолт: ХҮ-019573 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд өмнөх судалгаагаар 143 цооног, 42 сувгийн ажил хамаарагдаж байгаа бөгөөд нийт өрөмдлөгийн ажлын хэмжээ нь 31655.8 т/м. 2016 оны 10 сард өмнөх судалгааны ажлыг бататгах зорилгоор талбайн зүүн хэсэгт орших хүдрийн биет 8 болон хүдрийн биет 3/7-ийн мэдээлэлд тулгуурлан 2 ш цооногийг 479.2 т.м хэмжээтэй чөмгөн дээжлэлттэйгээр гүйцэтгэж нөөцийн тодотгол тооцооны тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан байна. Ордын ерөнхий структурт тэнхлэг нь 3/7 дугаар хүдрийн биет ерөнхийдөө зүүн хойш 40° суналтай. Баруун талаас 1 ба 2 -р хүдрийн биет, зүүн талаас нь 5-р хүдрийн биет хязгаарладаг. Ордын зүүн өмнө хэсгээр 6, 8-р хүдрийн биетүүд орж ирдэг.

Ордын геологийн нөөц: Дэлгэрхааны хайлуур жоншны ордын өмнөд хэсэг дэх хайгуулын ажлын үр дүнгийн нөөцийн тооцооны тодотгол тооцооны тайланг хэлэлцсэн ЭБМЗ-ийн 2017 оны 07 сарын 06-ны өдрийн ХХ-12-13 тоот дүгнэлийг үндэслэн гаргасан 2017 оны 10 сарын 16-ны өдрийн Н/89 дугаар бүхий АМГТГ-ын даргын тушаалаар “Тавт” нэртэй ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах жоншны хүдрийн нөөцийг бодитой /В/ зэргээр 368.462 мян.тн-оор, боломжтой /С/ зэргээр 588.755 мян.тн - оор, нийт бодитой болон боломжтой /В+С/ зэргээр 957.218 мян.тн-оор буюу 52.91% агуулга бүхий 506506 тн жоншны нөөц хүлээн авсан байна.

Ордын үйлдвэрлэлийн нөөц: Ордын батлагдсан геологийн бодитой болон боломжтой /В+С/ зэргээр 957.218 мян.тн хүдэр бүхий 52.91% агуулгатай 506506 тн жоншны нөөцийг ил, далд аргаар ашиглах явцад хаягдал, бохирдол тооцсон бөгөөд үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ 372.3 мян.тн хүдэр бүхий 49.4%-ийн 184.12 мян.тн жоншны нөөц тооцоологдсон байна.



Зураг 1. Төслийн байршил

1.2. 2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, АЖИЛЛАХ ГОРИМ

Уурхай жилийн турш ил уурхай 12 цагийн 1 ээлжээр, далд уурхай нь 7 цагийн 3 ээлжээр ажиллах зохион байгуулалттай байна. 2023 онд ил уурхайгаас 43.9 мян.м³ хөрс хуулж 50.36%-ийн агуулгатай 31.3 мян.тонн хайлуур жоншны хүдэр олборлох бөгөөд далд уурхайн уулын ажлаар 1203 м үндсэн болон бэлтгэл малталт нэвтэрч 6.88 мян.м³ хоосон чулуулаг гарган овоолго үүсгэхээр байна. Нийт 2023 онд ил уурхай болон далд уурхайн малталтаас гарах хөрс 50.72 мян.м³ байна.

Уул техникийн нөхцөл. Дэлгэрхааны жоншны орд нь газрын гадаргуугийн хувьд далайн түвшнээс дээш 1130-1210 м өргөгдсөн хөндий хоолой, ухаа гүвээ, нам толгод зонхилно. Хүдэр болон агуулагч чулуулгийн бат бөх дунджаар $f=9$ байна. Хүдэр болон чулуулгийн эзлэхүүн жин дунджаар 2.67 м³/тн байна.

2023 онд Хүдрийн биет-1-д хамаарах 1-р ил уурхайг үргэлжлүүлэн олборлоно, мөн Хүдрийн биет-8-д хамаарах 8.1, 8.2-р ил уурхайнуудын нээлт, олборлолтын ажлыг явуулахаар төлөвлөв. Ил уурхайгаас нийт 43.9 мян.м³ хөрс хуулж 50.36%-ийн агуулгатай 31.3 мян.тонн хайлуур жоншны хүдэр олборлон боловсруулна.

1.3. Ил уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан жилийн турш хоногийн 12 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллахаар төсөлд тусгасан.

Хүснэгт 1. Ажиллах горим

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Баяр ёслолын үеийн амралтын хоног	хоног	15
3	Цаг агаарын хүндрэл	хоног	10
4	Засвар үйлчилгээ	хоног	10
5	Өвлийн улирлын зогсолт	хоног	180
6	Уурхайн ажиллах хоног	хоног	150
7	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	1
8	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

Хүснэгт 2. Ил уурхайн хэмжээсүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ил уурхай
1	Ил уурхай №1	Гүн	12
2		Урт	106
3		Өргөн	22
4	Ил уурхай №8.1	Гүн	12
5		Урт	274
6		Өргөн	24
7	Ил уурхай №8.2	Гүн	12
8		Урт	155
9		Өргөн	33
10	Ил уурхайн хажуугийн өнцөг	градус	50-53
11	Хөрс хуулалтын ажлын доголын өндөр	м	5
12	Хүдэр олборлолтын ажлын доголын өндөр	м	5
13	Доголын налуугийн хэмжээ	градус	65
14	Ажлын доголын аюулгүйн тавцангийн өргөн	м	2
15	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн	м	5

Дээр авсан хэмжигдэхүүнүүдийг тусгасан дэвсгэр болон босоо, хөндлөн зүсэлт зургууд дээр ил уурхайг байгуулж ил уурхайн хүрэн дэх уулын цул, хүдэр болон хөрс хуулалтын хэмжээг тодорхойлсон ба зарим нөхцөлд мөргөцгийн налуугийн хэмжээ нь хүдрийн биетийн уналын өнцгөөр тодорхойлогдож байгаа болно.

1.4. Ашиглалтын систем

Дэлгэрхааны хайлуур жоншны ордын ил уурхайд хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ, экскавацлалт, авто тээвэр, гадаад овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэнэ. Тус ордыг оновчлолоор тодорхойлсон гүн хүртэл ил уурхайгаар хүдрийн биетийн уналын дагуу дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, хүдрийн биетийн суналын дагуу уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ. Хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа экскаваторын тусламжтайгаар автосамосвалд ачин, хөрс хуулалтын чулуулгийг ил уурхайн гадаад овоолгод, хүдрийг хүдрийн агуулах хүртэл тээвэрлэн байрлуулна. Экскаваторуудын техникийн үзүүлэлтүүд болон хүдэр, хөрсний чулуулгийн физик механикийн шинж чанаруудаас хамааруулан хөрс хуулалтын болон хүдэр олборлолтын ажлын доголын өндрийг 5 метр байхаар тооцоолсон болно.

Уулын үндсэн техник, тоног төхөөрөмжүүд. Уулын ажилд хэрэглэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг шинээр худалдаж авахаар энэхүү төсөлд тусгалаа.

Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

- 2.5 м3-ийн утгуурын багтаамжтай HYUNDAI-500LC маркийн урвуу утгуурт экскаватор
- 40 тн даацтай УТК-63 маркийн автосамосвалууд

- 110-203 мм-ийн диаметртай ROC-L8 маркийн өрмийн машин
- 3 м3 -н утгуурын багтаамжтай SDLG-933 маркийн утгуурт ачигч
- Туслах машин механизм (үйлчилгээний машинууд г.м.)

1.5. Ил уурхайн нээлт болон ашиглалтын дараалал

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 метрээс ихгүй зузаантайгаар шууд утгуурт ачигчаар түрж, утган автосамосвалд ачин ил уурхайн үржил шимт хөрсний гадаад овоолгод байрлуулна. Шимт хөрсийг хөрс хуулалтын хослол болох 3 м3-ын утгуурын багтаамжтай утгуурт ачигч 40 тн даацтай автосамосвалын хослолоор хуулна. Шимт хөрсийг эцсийн хүрээний гадна 50-80 м зайд овоолж зөөвөрлөж хураана. Өрнөлтгүй болсон овоолго, уурхайн бүрэн ашиглагдсан газарт техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсөөр хучна. Ирээдүйд уулын ажилд өртөх талбайн шимт хөрсийг хуулж шууд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газарт ашиглах боломжтой. Энэ нь шимт хөрсний овоолго хадгалалттай холбоотой зардлыг хэмнэх давуу талтай юм.

Үндсэн хөрс хуулалтын ажил: Үндсэн хөрсний чулуулгийг авахдаа урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа хөрсний гадаад овоолгод шилжүүлэх болно. Хөрс хуулалтын ажилд 2.5 м3 утгуурын багтаамжтай урвуу утгуурт гидравлик экскаватор, 40 тн даацтай автосамосвалууд тус тус ажиллана.

Хүдэр олборлолт: Хөрсний доголтой нэгэн адил, суналын дагуу чиглэсэн уурхайд хүдэр олборлолтын догол нь 5 м өндөртэй байна. Хүдэр олборлолтод 2.5 м3 утгуурын багтаамжтай урвуу утгуурт гидравлик экскаватор, 40 тн даацтай автосамосвалын хослолоор ажиллана. Автосамосвалууд хөрс, хүдрийн тээвэрлэлтэд ажиллах хосолмол ажиллагаатай байна. Ингэснээр эдгээр автосамосвалуудыг хөрс, хүдэр аль алинд нь ашиглах боломжтой юм. Үүний үр дүнд ачаа тээвэрлэлтийн бүтээмж сайжирч автосамосвалуудыг хөрс хүдэрт солбиж ажиллуулах сайн талтай.

Олборлолтын процесс

Хүдрийн биетүүд нь өөр хоорондоо 160 м-ээс 750 м хүртэл зайтай алслагдсан байна. Хүдрийн биет 1 нь баруун хойноос зүүн урагш чиглэлтэй, уналын өнцөг 50-54°, дунджаар 52° байна. 2023 оны төлөвлөгөөгөөр Ил уурхай-1-ийг үргэлжлүүлэн ашиглах болон Ил уурхай 8.1 болон 8.2-ийн нээлтийн ажил, Хүдрийн биет 8 дээр уулын ажил явуулахаар төлөвлөж байна.

Өрөмдлөгийн ажил. Доголын талбайг өрөмдлөгт бэлдэхдээ талбайд буй саад болох тоног төхөөрөмж бусад зүйлийг зайлуулах тэгшлэх, зам засах зэрэг ажлыг голдуу бульдозер хэрэглэж гүйцэтгэнэ. Засаж бэлдсэн талбайд маркшейдрийн хэмжилтээр цооног байрлах тэмдэглэгээг хийх ба шахсан хий усаар хангах өрөмдөх төхөөрөмжөө байрлуулж ажилд бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Хяналтын хэмжилтээр ажлын хэрэгжилтийг тодорхойлох ба өрөмдөх торны зай гүний зөрүү нь 0.3 м-ээс хэтрэхгүй байх ёстой. Цооног янз бүрийн учир шалтгаанаар нурж гүн нь хорогдох, цасаар дүүрэх, ус тогтох мөстөх зэрэг тохиолдолд дахиж өрөмдлөг хийж засварлана. Дэлгэрхааны хайлуур жоншны ил уурхайд 110-203 мм диаметртай цооног өрөмдөх техникийн үзүүлэлт бүхий өрмийн машиныг ажиллуулахаар сонгосон.

Манай компани нь Дэлгэрхааны хайлуур жоншны ордын өмнөд хэсгийн ил уурхайн тэсэлгээний ажлыг гэрээт аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гэрээт ажлын хөлсөнд тэсэлгээний материал, хэрэгслийн зардал бүгд багтсан болно.

Тэсэлгээний аюулгүй ажиллагаа. Хэрэв тэсэлгээний тооцоогоор чичиргээний аюултай үйлчлэх R_r радиусын хэмжээ нь бодит зайн хэмжээнээс давж байвал барилга байгууламжид чичиргээ доргио аюултай нөлөө үзүүлнэ. Иймээс аюулгүйн зайн талаас нь бодож нэг удаагийн тэсэлгээнд хамрагдах тэсрэх бодисын хэмжээг хязгаарлах арга хэмжээ авна.

Аюултай бүсүүдийн хилийг тогтоож тусгай тэмдэг байрлуулах ба тэсэлгээний өмнө харуул хамгаалалт гаргана. Тэсрэх материалыг зөөх байрлуулах цооногуудыг цэнэглэх холболтууд хийх зэрэг тэсэлгээний бэлтгэл ажиллагааг дүрэм журмын заалтуудын дагуу хийж гүйцэтгэнэ.

Тэсэлгээнээс өмнө аюултай бүсэд буй тоног төхөөрөмжүүдийг холдуулж аюулгүй бүсэд гаргах цахилгааны шугамыг таслах зэрэг аюулгүйн нөхцөл хангах ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Тэсэлгээг хэвшиж тогтсон өдөр цагт явуулна. Тэсэлгээний аюултай бүсээс хүмүүсийг гаргахын тулд анхааруулах дохио өгдөг. Уурхайнуудад ихэвчлэн дуут дохиог хэрэглэдэг. Зарим уурхайд бага цэнэг тэсэлж дохио өгч хэвшсэн байдаг. Тэсэлгээг удирдаж буй хүн бэлэн байдлыг хянаж дохио өгсний дараа тэсэлгээчин тэсэлгээг явуулна. Тэсэлгээний дараа тэсэлгээ явагдсан блокт үзлэг хийж гацаа (бааралт) үүссэн эсэхийг тогтооно. Тэсэлгээ хэвийн явагдсан бол дохио өгч тэсэлгээ дууссаныг мэдэгдэнэ. Хэрэв ямар нэгэн гацаа үүссэн байвал түүнийг устгах арга хэмжээ авна. Тэсэлгээ дууссан дохио өгөгдөөгүй тохиолдолд аюултай бүсэд орох үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөхгүй. Их хэмжээний тэсрэх бодис хэрэглэсэн буюу эсвэл гүн уурхайн гүний хэсэгт тэсэлгээ хийсэн бол тэсэлгээний дараах агааржуулалт явагдсаны дараа тухайн бүсэд хүн ажиллаж болно. Тэсэлгээ бүрийг хэрэгжүүлсэн тухай баримт үйлдэнэ.

Хөрсний овоолго

Овоолго. Ордын хөрс хуулалтад тээвэртэй ашиглалтын систем хэрэглэх бөгөөд хөрсийг гадаад овоолгод байршуулна. Хөрсний гадаад овоолго №1 нь I хүдрийн биетийн ил уурхайн зүүн талд байрлана. 2023 оны ашиглалтын жилд нэмээд 3.34 мян.м³ хөрс овоолно. Хөрсний гадаад овоолго №1 -н дундаж өндөр 2.4 м, эзлэхүүн 2023 оны эцсийн байдлаар 9.34 мян.м³ байна. Үржил шимт хөрсний овоолго №1-г ил уурхайн зүүн урд талд 2 метрээс ихгүй өндөртэйгээр 1.8 мян.м³ эзлэхүүнтэй овоолго байна. Хөрсний гадаад овоолго №2 нь VIII хүдрийн биетийн ил уурхайн баруун урд талд өмнө нь үүссэн 161.4 мян.м³ эзлэхүүнтэй хөрсний овоолго дээр нэмж байршуулна. VIII.1 ба VIII.2 хүдрийн биетүүдийн ил уурхайгаас нийт 40.61 мян.м³ хөрс хуулах бол далд уурхайн малталт нэвтрэлтээс 6.88 мян.м³ хөрс гарна. Хөрсний гадаад овоолго №2-н дундаж өндөр 10.0 м, эзлэхүүн эцсийн байдлаар 208.89 мян.м³ байна. Үржил шимт хөрсний овоолго №2-г ил уурхайн зүүн урд талд 2 метрээс ихгүй өндөртэйгээр 1.6 мян.м³ эзлэхүүнтэй овоолго байгуулна.

Хүснэгт 3. Овоолгын үндсэн үзүүлэлтүүд

№	Овоолгын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Үржил шимт хөрсний овоолго №1	мян.м ³	1.8 /0.12 га/
2	Хөрсний гадаад овоолго №1	мян.м ³	9.3 /0.24 га/
3	Үржил шимт хөрсний овоолго №2	мян.м ³	1.6 /0.11 га/
4	Хөрсний гадаад овоолго №2	мян.м ³	208.89 /2.08 га/
5	Овоолгын өндөр /дунджаар/	м	10.0
6	Овоолгын хамгийн их өндөр	м	19
7	Овоолгын налуу	градус	38

1.6. ДАЛД УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

Далд уурхайд 2023 онд явагдах ажил

Ордыг ашиглах эхний жилд ил уурхайн агаар ашиглах бөгөөд ил уурхайн ашиглалтын үйл ажиллагаатай зэрэгцэн далд уурхайн бэлтгэлт ажил болох үндсэн болон бэлтгэл малталтуудын нэвтрэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ

1.6.1. Далд уурхайн ажиллах горим

Далд уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагаас төсөл боловсруулах даалгаварт тусгагдсаны дагуу дараах байдлаар авч байна. Үүнд:

- Жилийн нийт хоног 365 хоног

- Үндэсний баяр, ёслолын хоног 5 хоног
- Засвар үйлчилгээ, бусад 33 хоног
- Уурхайн жилд ажиллавал зохих хоног 147 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 3 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг

1.6.2. Ашиглалтын систем

Геологи хайгуулын ажлаар тодорхойлогдсон хүдрийн биетийн үндсэн үзүүлэлтүүдийг үндэслэн 4 м хүртэлх зузаантай хүдрийн биетүүдийг шпурын цэнэгийн аргаар скрепер ашиглан хоршоолон нураах ашиглалтын системийг сонгох нь хамгийн тохиромжтой байна. Хүдэр хоршоолон нураах ашиглалтын систем: Энэ системд хүдэр нураалтын ажлыг блокийн восстающийгаас хүдрийн биет рүү цонх малталт нэвтэрч түүнээс цааш босоо холбогч малталт нэвтэрч мөргөцөг гаргана. Гар өрмийн машинаар мөргөцөгт шпур өрөмдөж хүдрийг шпурын цэнэгийн аргаар тэсэлж нураана. Нураагдсан хүдрийг хүдэр буулгуураар дамжуулан тээврийн хэрэгсэлд ачна.

Нурлын бүс. Нурлын бүс. Хүдрийн биетийг нээгч үндсэн малталтуудын байрлалд нурлын бүсийн хүрээ хязгаар зайлшгүй нөлөөлнө. Нанос дахь өнцөг : Нанос дахь шилжилтийн хязгаарын өнцөг нь усжилт ба наносны зузаанаас хамаарна. Ордын геологи хайгуулын ажлын үр дүнгийн тайлан материалаас үзэхэд ордын талбайн хэмжээнд хучаас хөрсний дундаж зузаан 0.3-0.8 м байна. Орд газар нь цаг агаарын эрс тэс уур амьсгалтай талархаг, говь хээрийн бүс нутагт хамрагдах боловч хуурай буюу хэвийн чийгшилтэй гэж үздэг. Дээрх нөхцөлөөр нанос дахь хязгаарын өнцгийн дундаж утга 30-45° байна. Районы чичирхийллийн зэрэг тооцсон итгэлцүүр 0.95, өндөржилт тооцсон итгэлцүүр 0.86, чулуулгийн чийглэгийн итгэлцүүр 1.53 зэргийг тооцвол наносон давхаргын хязгаарын өнцөг тус ордын хувьд 50-60° байх бөгөөд тооцоонд дундаж утгыг 55°-аар авлаа. Үндсэн чулуулаг дахь хязгаарын өнцөг: Хүдрийн биетийн агуулагч чулуулгаас хамаарах бөгөөд тус ордын хувьд агуулагч чулуулаг нь дунд палеозойн чулуулаг бүхий нэг төрлийн чулуулагтай гэж үзэн “Справочник по горнорудному делу” номны 106-112 хуудаснаас хүснэгт №III.18-ын дагуу хүдрийн биетийн хэвтээ ба босоо хажуугийн нурлын бүсийг хэвтээ хажуу талд хүдрийн биетийн уналын өнцгөөр $\beta = < 75^\circ$ гэж авсан.

Далд уурхайн нээлт Ордыг нээхдээ хүдэр болон хоосон чулуулгийн тээврийн зай болон, уурхайн жилийн хүчин чадал зэрэг үндсэн үзүүлэлтүүдээс хамааран ил уурхайн ёроолоос босоо гол амаар нээхээр төсөлд тусгасан байна. Босоо гол амны гүнзгийрэлтийг дээрээс доош чиглэлд гүйцэтгэнэ. Хүдэр болон хоосон чулуулгийг газрын гадаргуу дээр гарган тус тусад нь овоолго хийж хураана.

Ашиглалтын блокуудын восстающий малталт нь газрын гадаргуу болон дээд түвшний штрект бүрэн цоорч зохих бэхэлгээ болон тоноглоогоог бүрэн хийж гүйцэтгэсний дараа агааржуулалтын болон аваарын нөөц гарцын үүргийг гүйцэтгэнэ.

Босоо гол амыг хүдрийн биетийн хэвтээ талд, нурлын бүсийн хүрээний хүрээний гадна 20 м зайд $S=9.6 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтайгаар агуулагч чулуулаг дундуур нэвтэрч зохих бэхэлгээ тоноглоогооны ажлыг бүрэн гүйцэд хийж гүйцэтгэсний дараа хүдрийн биетэд перпендикуляр уурхайн үндсэн малталт болох $S=9.6 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтай квершлаг малталтыг хүдрийн биет хүртэл нэвтэрч түүнээсээ хүдрийн биетийн суналын дагуу хоёр тийш мөн адил хөндлөн огтлолын талбайтай тээврийн штрекүүдийг түвшин бүрт нэвтэрч хүдрийн биетийг нээгч бэлтгэл малталт болох орт малталтуудаар хүдрийн

биетийг нээнэ.

Блокийг ашиглалтад бэлтгэх дараалал. Далд уурхайн үндсэн малталт болох тээврийн штрекийг агуулагч чулуулаг дундуур нэвтрэх ба хүдрийн биетийн хэвтээ контактаар нэвтрэнэ. Тээврийн штрекний тэнхлэгээс орт малталт хүдрийн биетийг бүрэн огтлохоор (босоо хажуугийн контактыг 0.5м-ээс багагүй зайгаар огтолсон байх ёстой) нэвтэрч, дараа нь блокийн восстающий малталтыг хүдрийн биет дундуур дээд түвшин хүртэл нэвтрэнэ. Восстающий малталтаас хүдрийн биет дундуур цонх, өрөмдлөгийн камер малталт нэвтэрч зохих хамгаалалтын цулуудыг үлдээж, 2 дахь ил гадаргуу үүсгэх зорилгоор босоо холбогч малталтыг нэвтэрч хүдэр нураалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.6.3. Үндсэн болон бэлтгэл малталт нэвтрэлт

Босоо гол ам нэвтрэлтийн ажлын зохион байгуулалт Уурхайн босоо гол ам болон агааржуулалтын босоо гол амыг нэвтрэхэд дараах ажлуудыг хийнэ. Үүнд:

- Нэвтрэлт эхлэх мөргөцгийг бэлтгэх, ӨТА-аар 8-10 м нэвтрэлт хийсний дараагаар шаардлагатай бэхлэгээг хийх
- Нэвтрэлтийн тавцанг байрлуулах
- Уулын цулыг ачиж, гаргах
- Мөргөцгөөс ус зайлуулах.
- Агааржуулалт
- Гэрэлтүүлэг
- Малталтын түр болон байнгын тоноглоогооны ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Малталт нэвтрэлтийн ажилд тусгай зориулалтын механикжуулсан ажлын тавцанг ашиглах бөгөөд 3-4 хүний бүрэлдэхүүнтэйгээр ӨТА-ыг явуулна. Өрөмдлөгийн ажилд УТ- 28 маркийн гар өрөм ашиглах бөгөөд өгсөн тэсэлгээний ажлын паспортын дагуу тойрог хэлбэрээр өрөмдөж тэсэлнэ. Нэвтрэлтийн тавцанг тэсэлгээний мөргөцгөөс тогтмол аюулгүй зайд өргөж холдуулж байрлуулна. Босоо малталтыг ВОД-11П маркийн сэнсээр агааржуулах бөгөөд тэсэлгээний ажлын дараагаар малталтыг бүрэн агааржуулах юм. Тэслэгдсэн уулын цулыг ачиж тээвэрлэхдээ JTPB-1.2x1.2 маркийн өргөх төхөөрөмж мөн тусгай зориулалтын хөнөгөөр өргөж тээвэрлэх ба хөнөгт гар аргаар ачиж, мөргөцгийг цэвэрлэж дараагийн ажилд бэлтгэнэ. Малталт болон мөргөцгийг зөөврийн гэрэлтүүлгээр гэрэлтүүлэх ба ажилчид тус бүрийн хувийн гэрэлтэй байна.

Өрөмдлөгийн ажлаас үүссэн ус мөн мөргөцгөөс шүүрсэн усыг зөөврийн бага оврын усны шахуургаар соруулна. Босоо гол амыг бетонон бэхлэгээгээр бэхлэх бөгөөд бэхлэгээ мөргөцгийн хооронд 3-6 метрийн зайтай болсны дараагаар малталтыг бэхэлж байна. Уурхайн босоо гол ам нь 137 м тул /хүдрийн биетийн дээд түвшингээс 90 м гүн доош/ 37-48 м тутамд ашиглалтын түвшний босоо гол амны хашааг нэвтэрч бэхлэх, нэвтрэлтийн үеийн ус зайлуулах түр зумпфнуудыг хийнэ. Босоо гол амны малталт нэвтрэлтийн ажил дууссаны дараагаар тоноглох ажлыг доод талаас дээшээ чиглэлд байгуулж эхэлнэ.

Хэвтээ ба налуу малталт нэвтрэлтийн ажлын зохион байгуулалт Хэвтээ малталт нь агуулагч чулуулаг дундуур хүдрийн биетийн суналын дагуу нэвтэрч, хүдрийн биетийг нээх, судлын өргөн, нөөцийг тодорхойлох, хүдрийг нурааж олборлон тээвэрлэх, хүн явах, ачаа тээвэрлэх, нэвтрэлтийн агааржуулалтын хоолой, шахсан хийн хоолой болон усны хоолойнуудыг оруулахад зориулагдсан үндсэн малталт юм. Малталтын өргөн 2.6 м, өндөр 2.5 м. Малталтын хөндлөн огтлолын талбай нь 6.5 м² байна.

Нэвтрэлтийн ажлыг 2-4 хүний бүрэлдэхүүнтэй явуулна. Эхний ээлжийн өрөмдлөг-

тэсэлгээний ажлын дараа уурхайн ээлжийн мастер, нэвтрэгчдийн ахлагчийн хамт агааржуулалтын байдлыг шалгалт хийнэ. Үүний дараа тааз, хананы цохиулыг авч уулын цулыг Z17-AWмаркийн утгуурт ачигчаар УВО-0.8 маркийн тэргэнцэрт ачиж уурхайн аманд хүргэнэ.

Мөргөцгөөс уулын цулыг ачиж дууссаны дараа малталтын чиглэл, реперийг уурхайн ээлжийн мастер, нэвтрэгчдийн ахлагчийн хамт шалгаж дараагийн өрөмдлөгийн чиглэлийг тогтооно. Үүний дараа гар өрмийн машинаар өрөмдлөгийн ажлыг ОТА-ийн паспортын дагуу хийнэ. Өрөмдсөний дараа уурхайн ээлжийн мастерын зөвшөөрлийн дагуу тэсрэх материалыг авч мөргөцгийг цэнэглэж, бусад мөргөцгөөс хүмүүсийг гаргаж тэсэлгээний ажлыг явуулна.

Үндсэн болон бэлтгэл малталт нэвтрэлтийн ажлын тооцоо. Далд уурхайн хүчин чадал, үндсэн болон бэлтгэл малталтуудаар уулын цулыг тээвэрлэх, тухайн малталтад ажиллах техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн бүтээл, малталтаар өнгөрөх агаарын урсгал, уулын даралт зэргээс хамааруулан квершлаг, штрек малталтуудын тааз нь хүнхэр хэлбэртэй байна. Далд уурхайн малталт нэвтрэлтийн ажлаар 2023 онд нийт 1203 м үндсэн болон бэлтгэл малталт нэвтрэх бөгөөд 20.3 тонн тэсрэх бодис хэрэглэхээр байна

1.7. Баяжуулах

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Дэлгэрхааны хайлуур жоншны ордын хүдрийн найрлага, шинж чанар, технологийн туршилт судалгааны үр дүн болон төсөл захиалагчийн даалгаварт үндэслэн хайлуур жоншны хүдрийг гар аргаар ялгах болон гравитацийн аргаар баяжуулахаар тусгасан. Хайлуур жоншны хүдрийн баяжигдах шинж чанарыг судлах зорилгоор 1989 онд ордын талбайгаас 15 тн сорьц авч ГТЛ-д технологийн туршилт, шинжилгээг гүйцэтгүүлсэн байна. Технологийн туршилтаар дээжид минераграф-петрограф-минералогийн болон бодисын найрлагын судалгаа хийж үр дүнд нь гар ялгалт, гравитаци болон флотацийн технологиор баяжуулах туршилтуудыг хийж гүйцэтгэсэн. Туршилтын үр дүнд ФК-75, ФГ-75, ФФ-95 маркийн хайлуур жоншны баяжмал гарган авах боломжтой нь тогтоогдсон. Төсөлд Дэлгэрхааны хайлуур жоншны ордын хүдрийн шинж чанар баяжуулах туршилт судалгааны хураангуй, баяжуулах үйлдвэрийн технологийн сонголт, тооцоо усны хэрэглээ, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт хаягдлын сангийн төлөвлөлт болон баяжуулах үйлдвэрийн дэд бүтцийн тооцоог хийж гүйцэтгэсэн.

Хайлуур жоншны хүдэр баяжуулах технологи. Дэлгэрхааны хайлуур жоншны ордоос олборлосон хүдрийг баяжуулах төхөөрөмжид өгөхийн өмнө гар ялгалтаар бүхэллэг жоншийг ялгаж үлдсэн таваарын хүдрийг баяжуулах төхөөрөмжийн тэжээл болгон өгнө. Ордыг ашиглах хугацаанд 49.45%-ийн хайлуур жоншны агуулгатай нийт 372.31 мян.тн хүдэр олборлон 1-р шатны шигшүүрээр ангилж, +25 мм ширхэглэлтэй хүдрийг гар аргаар ялган ФК-75 маркийн 64.07 мян.тн металлургийн баяжмалыг гар аргаар ялган, үлдэх 59.55 %-ийн дундаж агуулгатай 221.7 мян.тн хүдрийг 2-р шатны шигшүүрээр 0-5 мм, 5-25 мм-ээр ангилан ялгаж 0-5 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг дотоодод борлуулах, үлдэх 5-15 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг хүндийн хүчний аргаар баяжуулах төхөөрөмжид баяжуулан ФГ-75 маркийн баяжмал үйлдвэрлэнэ. Хайлуур жоншны хүдрийг гравитацийн аргаар баяжуулах технологийг сонгохдоо захиалагч талаас ирүүлсэн төслийн техникийн даалгавар болон Дэлгэрхааны хайлуур жоншны хүдрийг ГТЛ-д боловсруулсан технологийн туршилтын тайлангийн үр дүн, санал зөвлөмжид тулгуурлан баяжуулах

технологийг сонгон доор дурдсан технологийн ерөнхий шийдлүүдийг гаргасан. Баяжуулах үйлдвэр нь хүдэр хүлээн авах талбай, бүхэллэг жоншийг гар аргаар ялгах хэсэг, хүдэр жигдрүүлэх талбай, шигшин ангилах хэсэг, баяжуулах хэсэг, хаягдлын сан, эргэлтийн усны сан, хаягдлын овоолго, хяналт шинжилгээний лаборатори, баяжмал ачих тээвэрлэх талбай зэргээс бүрдэнэ.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газарзүй: Дэлгэрхаан хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг ба Батноров сум, Бэрх тосгоны төвөөс 13 км-т Хэнтийн уулархаг өндөрлөгийн зүүн өмнөд хэсэгт, харьцангуй нам оройтой, бэсрэг уулсын хэсэгт хамаарагдана. Судалгааны талбайн дийлэнх хэсэг нь далайн түвшнээс дээш +1135-1196 м өргөгдсөн, 40-50 м харьцангуй өндөржилттэй толгодорхог гадаргатай байна.

Талбайн усан хагалбар болох нам уулс, гүвээ нь өргөргийн дагуу чиглэлтэй урт, нарийн сунасан тогтоцтой бөгөөд энэ нь тухайн районы тектоник эвдрэлийн чигтэй давхацдаг.

Уур амьсгал: Эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн болон хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, жилийн дундаж хэм нь -20С. Хамгийн хүйтэн үе нь 12-р сараас 2 сарын эхэн байдаг ба -40 С хүртэл хүйтэрдэг бөгөөд хамгийн халуун сар нь 7-8-р сар, +40 С хүртэл дулаантай байдаг. Жилийн хур тунадасны хэмжээ 200 мм-т хэлбэлздэг ба улирал бүрд харилцан адилгүй буудаг. Үүний 70-85% нь зуны улиралд бороо хэлбэрээр буудаг. Өвөлд 20-60 мм цас ордог ба хөрсний хөлдөлтийн гүн дунджаар 3 м хүртэл, олон жилийн цэвдэг байхгүй. Хаварт бараг тогтмол салхи шуургатай байдаг ба салхины чиглэл голдуу баруун хойноос зүүн урагш, хурд дунджаар 4.7 м/сек гэх боловч зарим үед 15-20 м/сек, үе үе 20-24м/сек хүрч хүчтэй цасан болон шороон шуурга тавьдаг.

Ургамлын бүрхэвч муутай, тачир сийрэг өвстэй, энд тэнд алтан харгана, зэрлэг бүйлсний намхан бутнууд ургасан байдаг, хөндий, хуурай нууруудын захаар дэрс, цөөн тоогоор шагшуурга ургадаг. Ой мод сөөг байхгүй. Амьтны аймаг олон төрөлтэй, араатан амьтдаас чоно, үнэг, хярс, мануул, мэрэгчдээс туулай, цөөн тоогоор тарвага, олон төрөл тооны хулганатай, хэвлээр явагчдаас бамбай толгойт могой, хонин ба могой гүрвэлтэй, жигүүртнээс бүргэд, элээ, тогоруу, харцага, сар, ногтруу, тагтаа, нуур тогтсон үед ангир, нугас, галуу түр байрладаг.

Хүн ам, зам харилцаа, дэд бүтэц: Тухайн районд хүн ам сийрэг 1 кв.км талбайд 0.2-0.6 хүн ам ноогддог. Хамгийн олон хүнтэй нь Батноров сум, Бэрх тосгон ба 1500-4000 хүн амтай. Зам харилцааны хувьд харьцангуй сайн хөгжсөн. Улаанбаатараас Дэлгэрхаан орд хүртэл 340 км цардмал зам, 80 км сайжруулсан шороон замтай, жилийн аль ч улиралд саадгүй зорчих боломжтой. Төмөр замын хувьд Багануураас 270 км, Бор-Өндрөөс 270 км зайтай. Бэрх тосгон 110 кВт-ийн өндөр хүчдэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон.

Бэрх тосгонд эмнэлэг, шуудан холбоо, цахилгаан станц, дэлгүүр хоршоо, зочид буудал, халуун ус зэрэг нийтийн үйлчилгээний газрууд байдаг. Хүн амын ихэнх нь нүүдлийн мал аж ахуй, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг байна.

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

Ордыг ашиглах эхний жилд ил уурхайн агаар ашиглах бөгөөд ил уурхайн ашиглалтын үйл ажиллагаатай зэрэгцэн далд уурхайн бэлтгэлт ажил болох үндсэн болон бэлтгэл малталтуудын нэвтрэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.2. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2023 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.3.Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах.
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах.
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх, тоосжилт дарах бодис хэрэглэх.
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.

- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх
- Үржил шимт хөрсний алдагдал, өгөршлийг бууруулахын тулд хөрсний овоолгыг ургамалжуулах, шимт хөрсийг аль болох богино хугацаанд нөхөн сэргээлтэд ашиглах
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдэд тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах
- Барилга, байгууламж байршуулсан хэсэгт үерийн ус зайлуулах шуудуу татах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах

Шимт хөрс хадгалах хамгаалах талаар

Хөрс хуулалтын өмнө тухайн талбайг цэвэрлэж, техник хэрэгслийг саадгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Хуулсан шимт хөрсийг дээрх стандарт шаардлагуудад заасны дагуу нөхөн сэргээлтэд ашиглах хүртлээ тусгай талбайд овоолж хадгалах ба ингэхдээ дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу болон бусад хаягдалд дарагдан бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
2. Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын гадна талаар салхи, борооны элэгдлээс хамгаалах хамгаалалт хийх, овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлэн олон наст өвслөг ургамал тариалах
3. Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцөлийг хангасан байх шаардлагатай ба шимт хөрсний овоолгын өндөр нь 5 м-ээс илүүгүй байх

Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолтын бүртгэл, хяналтын ажлыг зохион байгуулах, тогтмолжуулах

Уурхайн тоосжилттой тэмцэх арга хэмжээ

Ухаж ачих процессын үед үүсэх тоосны хэмжээг бууруулах зорилгоор авто замыг байнга услах, замын материалыг оновчтой сонгох. Олон салаа зам гаргахаас сэргийлж уурхайн дотоод ба гадаад авто замын сүлжээг оновчтой төлөвлөх.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

2023 онд хийгдэх нөхөн сэргээлтийн ажил.

2023 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй. Харин хөрсний гадаад овоолгод 2.32 га талбай өртөх бөгөөд налуужилт хэвгийжүүлэлтийн ажил хийгдэх бөгөөд зардал нь ашиглалтын зардалд орсон

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

- Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллах;
- Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн соёл, өв уламжлалыг хүндэтгэж хамгаалах;
- Цаашид ашиглах шаардлагагүй хөндөгдсөн талбайнуудыг тухай бүрд нөхөн сэргээж, орон нутагт хүлээлгэж өгөх;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, компанийн чадамжийн хэмжээнд хувь нэмрээ оруулах;
- Батлагдсан БОМТ 2023-г хамгийн багадаа 90%-ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэх;
- Хүрээлэн буй орчны талаар ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх;
- Байгаль орчны мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;
- Төрийн захиргааны байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хяналт шалгалт, БО-ны аудитаас гарах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “Баян чулуут газар” ХХК-ийн “Дэлгэрхаан” хайлуур жоншны ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч “Баян чулуут газар” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлнэ.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	9	
1	Агаарын чанар	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслог тогтоосон хугацаанд нь сольж байна.	Уурхайн хэмжээнд	Мот/цаг	Уулын ажлын төсөвт орсон	Үйл ажиллагаа эхлэхэд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 MNS 3384:82 - Агаарын тухай хууль
		Уурхайн замын сүлжээг оновчтой төлөвлөх, тоосжилт ихтэй үед замуудыг услах	Уурхайн хүрээнд	-	2,000,000	Үйл ажиллагаа эхлэхэд	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Уулын ажлын төсөвт орсон	Үйл ажиллагаа эхлэхэд	Агаарын тухай хууль
	Нийт	2 000,000					
2.	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө	Төслийн хүрээнд		Дотоод үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагаа эхлэхэд	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах	Үйл ажиллагааны зардалд орно			Үйл ажиллагаа эхлэхэд	
		Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахиж ажиллана.			1,000,000		
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Уст цэгт	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон		Төслийн хугацаанд	

	Нийт	1,000,000					
3.	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагаа эхлэхэд	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай, авто зогсоол	-	500,000	Үйл ажиллагаа эхлэхэд	
		Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Уурхайн хэмжээнд	-	500,000		
	Нийт	2,000,000					
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Олон салаа зам гаргахгүй байна.	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	500,000	Төслийн хугацаанд	
		Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Уурхайн зам, уурхайн хил хязгаар		1,000,000	Үйл ажиллагаа эхлэхэд	
		Автомашинны зогсоолыг хайргаар хучих	Засварын талбай, зогсоол		500,000	2023 ондоо	
		Шимт хөрсний овоолго үүсгэж, ургамалжуулж хадгалах	Уурхайн хэмжээнд		1,000,000	Үйл ажиллагаа эхлэхэд	
	Нийт	3,000,000					
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал	7,000,000					

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус уурхай нь 2023-2027 он хүртэлх 5 жилийн хугацаанд нөхөн сэргээлтийн хүрээнд зөвхөн шимт хөрсний нөөц бий болгох, одоогийн шимт хөрсний чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх бөгөөд нөхөн сэргээлтийн ажил 2027 оноос эхлэхээр ТЭЗҮ болон БОННҮ-нд тусгагдсан болно. Гар аргаар алт олборлогчдод өртсөн талбайд Уулын ажилтай зэрэгцэн маркшейдэрийн хэмжилт хийж нэмэлтээр нөхөн сэргээх газрын хэмжээг тооцоолно.

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

“Баян чулуут газар” ХХК нь дүйцүүлэн хамгаалах ажлаар БОННҮ-ний тайланд тусгагдсан "Зэрлэг амьтан хамгаалах судлах нийгэмлэг" ТББ-ийн Хэнтий аймгийн Хурхын хөндийд хийгдэж байгаа нүүдлийн шувуу бөгжлөлийн судалгаа мөн ус намгархаг газрын амьдрах орчны судалгаа, хамгааллын судалгаанд хөрөнгө оруулах, Бэрхийн далд уурхайд хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа цаашдын төсөл хөтөлбөрүүдэд хамтарч ажиллахад зардлыг зарцуулахаар төлөвлөсөн ба Хэнтий аймгийн 0.4 га-аас ихгүй талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөж байна.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээ-ний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэг-жийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	УАТ-ний дагуу байгаль орчны байцаагчаас санал авч дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлыг сум, орон нутагт хийж гүйцэтгэнэ.	2.5 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ.	Сумын хэмжээнд	2.5 га	-	5,000,000	2023 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Төслийн талбайд 2023 онд 300 ш мод заасан чиглэлд тарихаар төлөвлөв	0.5 га талбайд	Төслийн талбайд	300 ш	10,000	3,000,000	2023 онд	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд
	Нийт					8,000,000		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Баян чулуут газар” ХХК-ийн “Дэлгэрхаан” хайлуур жоншны ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Батноров сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Сургалт сурталчилгааны зардалд 1 000,000 төгрөг төсөвлөсөн.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Аюултай бодис асгарах, хяналтаас гадуурх дэлбэрэлт, хүний эрүүл мэнд муудах	Химийн бодисын хэрэглээнд хөндлөнгийн хяналт тавих 1. Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээ 2. Агааржуулалтын систем, галын хор, саармагжуулагч бодисээрэг шаардлагатай материалын бүрдэл 3. Тусгай зөвшөөрөл,	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	4 шалгалт	-	1500,000	Сар бүр	Жилийн эцсийн тайланд тусгана	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам,

		ослын үед ажиллах төлөвлөгөө, ажилчдыг аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтад хамруулсан байдал							БОННУ
2	Гал түймэр, нуралт, Авто техникийн осол, үер, дэлбэрэлт	Осол, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	1 төлөвлөгөө	-	200,000	Жилийн эхнийсард	Осол, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
3		Болзошгүй аюул ослын үед нөхцөл байдлыг холбогдох байгууллагад тогтмол мэдээлэх, шаардлагатай үед нэмэлт дайчилгаа зохион байгуулах	Төслийн хүрээнд	Тодорхойлох боломжгүй	-	-	Жилийн турш	Аюултай бодис алдагдсан тухай Осол, зөрчлийн мэдээлэл	
		Нийт				1,700,000			

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), техникт ашигласан хаягдал тосны хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6
1	Ахуйн	Ахуйн хог хаягдлын цэгийг сумын БО-ны байцаагчаар тогтоолгож, Засаг даргаар захирамж гаргуулах		Үйл ажиллагаа эхлэхэд	
		Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	500,000	Үйл ажиллагаа эхлэхэд	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21 -р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл Жилд 2 удаа
		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж түр хадгалах зориулалтын хогийн бункер байрлуулах	500,000	Үйл ажиллагаа эхлэхэд	
		Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг сумын төвд 2-догч түүхий эд авах цэгт тушаах	-	Үйл ажиллагаа эхлэхэд	
		Дугуй, модны хаягдлыг дахин ашиглах, орон нутгийн хэрэгцээнд өгөх	-	Сард 1 удаа	
		Автомашины сэлбэг, төмрийн хаягдлыг мэргэжлийн байгууллагад гэрээний дагуу нийлүүлэх	-	3 сард 1 удаа	
		Цаас, цаасны хаягдлыг цаас боловсруулах үйлдвэрт тушаах	-	1 сард 1 удаа	
2	Аюултай	Шатах тослох материалаар хөрс бохирдсон тохиолдолд асгаралтыг цэвэрлэж, саармагжуулах	500,000	Үйл ажиллагаа эхлэхэд	
		Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулж зохих газарт нийлүүлэх	500,000	Үйл ажиллагаа эхлэхэд	
		Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Гэрээ байгуулах	7 хоногт 1 удаа	
Нийт			2,000,000		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах арга хэмжээ авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2023 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, Гадаргын болон гүний усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаа төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Хүснэгт 3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1	Агаар	Засварын талбай ажилчдын хотхон, уурхай, уурхайн зам	10 -р сард	4 цэгт 1 удаа	100,000	400,000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ СО-ын агууламж, Хүнд металл тодорхойлох, Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2	Хөрс	Ахуйн бохир усны хаягдал орчимд, шимт хөрсний овоолго, засварын газар, эрүүл талбай	10 8-р сард	4 цэгт 1 удаа	65,000	260,000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
	Ус	Унд ахуйн ус,	10 -р сард	2 цэгт 1 удаа	200,000	400,000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын

						шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар)	зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/А/171 тоот тушаалын 2-р хавсралт.
	Нийт				1,060,000		

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 4. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв Төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			3	4	5	
	1	2				6
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдүүлнэ	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд			Уурхайн дарга
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	1,000,000	7 р сард			Уурхайн дарга
3.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Дотоод төлөвлөлтөөр	11-р сар			“Баян чулуут газар” ХХК-ийн удирдлагууд
4.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих		Сар бүр			“Баян чулуут газар” ХХК-ийн удирдлагууд
	Нийт	1,000,000				

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төгрөг	Хариуцан зохион байгуулах тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын БО-ны мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.		9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.	
2		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн БОАЖГазарт хүргүүлж, төслийн талбайд хийсэн ажлуудыг танилцуулна.		11 сарын 1-нд багтаан			
3		Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.		Тухай бүрд			
	Нийт	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон.					

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 6. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	7000.0
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, тэр бум мод	8000.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2000.0
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1000.0
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1700.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1060.0
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1000.0
10	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	-
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн		21760.0

2023 оны БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт төсөв **21 760 000** төгрөг болж байгаа бөгөөд үүний **50% нь 10 880 000** төгрөг болж байна.

Бид 2022 онд Байгаль орчин нөхөн сэргээх барьцаа хөрөнгө 11 110 000 /Арван нэгэн сая/ төгрөгийг төрийн сангийн дансанд байршуулсан бөгөөд 2023 оны үйл ажиллагаа эхлэх гээд бичиг баримтаа бүрдүүлж байна. 2022 оны барьцаа хөрөнгийг 2023 онд шилжүүлэн байршуулна.